



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

64101 Баянхонгор аймаг
Баянхонгор сум, Номгон баг
Вэбсайт: www.bayankhongor.gov.mn
Утас/Факс: (976) 7044 2273

2021.07.09 № 2/1060
танай _____-ны № _____-т

Г ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ Г
ЭРХЛЭХ ГАЗАРТ

Иргэдээс төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн 2021 оны эхний хагас жилийн тайлан мэдээг хүргүүллээ.

Хавсралт 6 хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ЭНХЖАРГАЛ



• 616210263

**ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН
ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ,
ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН
ТАНИЛЦУУЛГА**

2021 оны 06 дугаар сарын 09

Номгон

Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, Нутгийн захиргааны байгууллагууд нь иргэдээс санал, хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэхдээ “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/259 дүгээр захирамжаар батлагдсан “Аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын дагуу төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангаж, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, тэдний санал, хүсэлтийг бодлого шийдвэртээ тусгаж ажиллах зарчмыг баримтлан ажиллалаа.

Аймгийн хэмжээнд төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн нийт 5913 санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авснаас аймгийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт 124 санал, хүсэлт, өргөдөл, гомдол, Засаг даргын дэргэдэх хэлтэс, агентлагт 2823, сумдын Засаг даргын Тамгын газарт 2654, Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд 312 санал, хүсэлт, өргөдөл, гомдол ирсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт бичгээр 124 өргөдөл ирснээс 92 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж 32 өргөдөл гомдлыг холбогдох байгууллагад шилжүүлсэн. Нийт ирсэн өргөдлийг агуулгаар нь ангилж үзвэл ажил хүссэн 16, гэр хүссэн 18, газрын асуудлаар 17, мөнгөн тусламж хүссэн 16, бусад асуудлаар 57 өргөдөл, хүсэлт ирсэн байна.

Амьжиргааны баталгаажих түвшинээс доогуур орлоготой болон эмчилгээний зардал, мөнгөн тусламж хүссэн 5 иргэнд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 1.100.000 төгрөгийн буцалтгүй тусламж олголоо.

Аймгийн Засаг даргын 2014 оны 202 дугаар захирамжаар батлагдсан “Төрийн байгууллага, албан тушаалтанд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ыг аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/259 дүгээр захирамжаар “Аймгийн нутгийн захиргааны байгууллага,

албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам"-ыг шинэчлэн батлууллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 17-ны А/65 дугаар тушаалаар "Иргэдээ сонсьё" аяныг эхлүүлж, "Иргэдээ сонсьё-Баянхонгор" пэйж хуудсаар төрийн нэр бүхий 8 байгууллагын үйл ажиллагаа, цахим хуудасны ил тод байдал, үйлчилгээний чанар хүртээмж иргэдийн сэтгэл ханамж ямар байгааг тандах зорилгоор судалгаа хийх ТББ-ыг сонгон шалгаруулсан. Тус шалгаруулалтад "Хөгжилд залуучуудын оролцоо түншлэл" төрийн бус байгууллага шалгарч 10 хоногийн хугацаанд судалгааг хийж дүнг нэгтгэсэн.

Мөн "Зөөлөн чих" пэйж хуудсыг ажиллуулан иргэдээс санал сэтгэгдлийг нь хүлээн авсан. Судалгааны үр дүнгийн мэдээллийг аймгийн удирдлагууд болон тухайн судалгаанд хамрагдсан 8 байгууллагуудын удирдлагуудад танилцуулж гарц, шийдлийн талаар мэдээлэл солилцох хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт удирдлагууд болон холбогдох хэлтсийн мэргэжилтэн, ТББ, иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүдээс бүрдсэн нийт 36 хүн оролцож санал бодлоо хуваалцаж, хэлэлцүүлгээс гарсан санал, хүсэлт, шийдвэрлэх асуудлуудын талаар зөвлөмжийг тухайн байгууллагуудад нь хүргүүлсэн. Төрийн байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмж, цахим хуудасны ил тод байдал сайжирсан үзүүлэлттэй байна.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн нээлттэй утас 70440001 дугаараар 312 дуудлага хүлээн авснаас аймгийн онцгой комисстой холбоотой 265, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 35 санал хүсэлт ирүүлсэн хүсэлтийг тухай бүрд нь холбогдох албан тушаалтанд шилжүүлэн ажилласан.

Засгийн газрын 1111 төвд 23 санал, гомдол ирүүлснийг холбогдох албан тушаалтанд шилжүүлэн шийдвэрлүүлж иргэнд хариуг утсаар мэдэгдэж ажилласан байна.

Аймгийн Засаг дарга 7 хоног бүрийн Пүрэв гарагт иргэдийг хүлээн авч иргэдийн санал хүсэлтийг сонсож байна. 2021 оны эхний хагас жилд нийт 71 иргэнтэй биечлэн уулзалт хийж, тэдний тавьсан асуудлыг шийдвэрлэн ажилласан. Аймгийн Засаг даргатай уулзаж буй иргэдийн 17 нь ажлын байр, 18 нь тусламж дэмжлэг хүсч байгаа бол гэр хүссэн 5, төсөл хөтөлбөртэй холбоотой 15, газрын асуудлаар 7, хүнсний талонд хамрагдах хүсэлтэй 2 иргэн уулзсан байна.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төв нь хагас жилийн байдлаар иргэн аж ахуйн нэгж байгууллагад төрийн үйлчилгээг нэг цэгээс түргэн шуурхай, нээлттэй үзүүлсэн

Үүнд: E-hutuch.mn цахим хуудасны талаар боршур бэлтгэн үйлчлүүлсэн иргэдэд тарааж мэдээлэл өгсөн мөн E mongolia цахим хуудаснаас 225, Хур системээс 2392 иргэнд лавлагаа гаргаж үйлчилсэн байна. Мөн 5 төрийн байгууллагын 180 гаруй төрлийн үйлчилгээг 23614 иргэнд үйлчилсэн байна.

Онцгой байдлын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шүүхийн шинжилгээний алба, Заг, Жинст, Гурванбулаг, Баян-Өндөр, Эрдэнэцогт, Баянговь сумын Засаг даргын Тамгын газрын өргөдөл, гомдлын асуудал хариуцсан мэргэжилтэн нар 2021 оны эхний хагас жилийн мэдээ тайлан ирүүлээгүй тул хариуцлага тооцох талаар байгууллагын удирдлагуудад аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан тоот хүргүүлээ.

ТАЙЛАН БИЧСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН *Б.Наранцэцэг* Б.НАРАНЦЭЦЭГ

ХЯНАСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *Д.Энхжаргал* Д.ЭНХЖАРГАЛ



ИРГЭДЭЭС ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН
ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

2021 оны 07 дугаар сарын 09

Номгон

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлтийн хувиар
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шилжүүлсэн	Хугацаа болоогүй	
1	Аймгийн Засаг даргын Тамгын газар	124	92	32			100%
2	Хэлтэс, агенилаг	2823	2698	12		113	95.9%
3	Сумдын ЗДТГ	2654	2480	32		142	94.6%
4	Төрийн үйлчилгээний нэгдсэн төв 70440001	312	213				
Дүн		5913	5483	76		255	

МЭДЭЭ НЭГТГЭСЭН:

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН *Б.Наранцэцэг* Б.НАРАНЦЭЦЭГ

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *Д.Энхжаргал* Д.ЭНХЖАРГАЛ



ИРГЭДЭЭС ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА,
АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ,
ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ ХЭЛБЭРЭЭР

2021 оны 07 дугаар сарын 09

Номгон


№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдлын тоо	Үүнээс					
			Бичгээр	11-11 төвөөс	Цахим хэлбэрээр	Утсаар	Биечлэн уулусан	Бусад
1	Аймгийн Засаг даргын Тамгын газар	124	124					
2	Хэлтэс, агенилаг	2823	2504		1	195	123	
3	Сумдын ЗДТГ	2654	2566			5	10	
4	Төрийн үйлчилгээний нэгдсэн төв 70440001	312		23		289		
Дүн		5913	5194	23	1	489	133	

МЭДЭЭ НЭГТГЭСЭН:

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН *Б.Наранцэцэг* Б.НАРАНЦЭЦЭГ

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *Д.Энхжаргал* Д.ЭНХЖАРГАЛ



ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТИЙН
АГУУЛГА ХУВЬ

2021 оны 07 дугаар сарын 09

Номгон

№	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал Тоо нийт өргөдөл, гомдлын эзлэх хувь
1	Баянхонгор	<p>Нийт 5913 өргөдлөөс</p> <p>1.Хүсэлт-5692 (96.2%)</p> <p>2.Санал-203 (3.4%)</p> <p>3.Гомдол-18 (0.3%)</p> <p>Ажил хүссэн-197 (3.33%)</p> <p>Тусламж дэмжлэг хүссэн-378 (6.3%)</p> <p>Нийгмийн даатгалын асуудлаар-564 (9.53%)</p> <p>Газрын асуудлаар-720 (12.1%)</p> <p>Гэр хүссэн-38 (0.64%)</p> <p>Халамжийн асуудлаар-1571 (26.5%)</p> <p>Иргэний бүртгэлийн асуудлаар-458 (7.74%)</p> <p>Худалдаа үйлчилгээ явуулах тусгай зөвгөөрөл хүссэн-115 (1.9%)</p> <p>Байгууллагын дотоод асуудлаар-244 (4.12%)</p> <p>Бусад асуудлаар-1628 (27.5%)</p>

МЭДЭЭ НЭГТГЭСЭН:

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН *Наранцэцэг* Б.НАРАНЦЭЦЭГ

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *Д.Энхжаргал* Д.ЭНХЖАРГАЛ

